

Хан-Уул дүүргийн Статистикийн хэлтэс

# ДҮҮРГИЙН БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ



Улаанбаатар хот  
2016 он



**Сургуулийн өмнөх боловсрол:** 2015-2016 оны хичээлийн жилд Нийслэлийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын 564 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 15.6 хувь буюу 88 нь Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байршин үйлчилгээ үзүүлж байна. Үүнээс төрийн өмчийн цэцэрлэг 25, төрийн өмчийн бус цэцэрлэг 63 байна.


Дүүргийн төрийн өмчийн цэцэрлэгийн тоо өмнөх оны хичээлийн жилтэй харьцуулахад 2-оор нэмэгджээ. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 88 цэцэрлэгийн үндсэн бүлэгт 11520 хүүхэд хамрагдан хүмүүжиж байгаа бөгөөд өмнөх оны хичээлийн жилтэй харьцуулахад цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо 1882-аар өссөн байна.

Нийт 1307 ажилчдаас 29.3 хувь буюу 383 нь үндсэн багш (үүнээс 375 буюу 97.9 хувь нь эмэгтэй), 27.2 хувь буюу 355 нь туслах багш (үүнээс 100 хувь нь эмэгтэй) байна.


Хүснэгт 1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын зарим үзүүлэлт

Үзүүлэлт	2009/10	2010/11	2011/12	2012/13	2013/14	2014/15	2015/16
СӨБ-ын байгууллагын тоо	26	30	37	45	62	76	88
СӨБ-д хамрагдагчдын тоо	4492	5505	6201	7218	8481	9638	11520
Үндсэн багшийн тоо	156	172	201	232	283	317	383

Зураг 1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын тоо



Зураг 2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдагчид



2015-2016 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь 71.6 хувьтай байна. Нийт СӨБ-д хамрагдагчдын 5120 нь эмэгтэй хүүхэд байна. Хувилбарт сургалтанд нийт 57 хүүхэд хамрагдсан нь өнгөрсөн оны хичээлийн жилтэй харьцуулахад 25-аар цөөн хүүхэд хувилбарт сургалтанд хамрагджээ.

Хүснэгт 2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүлгийн тоо, 2015/16 онд

	Бүлгийн тоо	Үүнээс:											
		Цэцэрлэгийн	Үүнээс:							Хувилбарт сургалтын	Үүнээс:		
			Ясли	Бага	Дунд	Ахлах	Бэлтгэл	Холимог	Ээлжийн		Нүүдлийн	Явуулын	
Бүгд	366	363	9	90	90	90	68	16	3	3	-	-	
Төрийн	165	163	5	32	39	43	44	-	2	2	-	-	
Төрийн бус	201	200	4	58	51	47	24	16	1	1	-	-	

Зураг 3. СӨББ-д ажилладаг үндсэн багшийн тоо



Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийт 383 үндсэн багш ажиллаж байгаагаас 11.5 хувь буюу 44 багш нь 50-59 насны багш, 29.0 хувь буюу 111 багш нь 40-49 насны багш, 24.3 хувь буюу 93 нь 30-39 насны багш, 35.2 хувь буюу 135 багш нь 30 хүртэлх насны багш эзэлж байна. Хан-Уул дүүргийн СӨББ-ийн үндсэн нэг багшид 30 хүүхэд ногдож байна.

**Бага, дунд боловсрол:** 2015-2016 оны хичээлийн жилд Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын 29 сургуульд 22741 хүүхэд суралцаж байгаагаас эмэгтэй нь 11154 хүүхэд суралцаж байна. Өнгөрсөн оны хичээлийн жилтэй харьцуулахад суралцагчдын тоо 20.5 хувь буюу 3863 хүүхдээр нэмэгдсэн байна.

2015-2016 оны хичээлийн жилд Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын сургуульд нийт 3202 хүүхэд 1-р ангид шинээр ангид элсэн орсон нь өнгөрсөн оныхтой харьцуулвал 541 хүүхдээр буюу 20.3 хувиар өссөн байна. 1-р ангид шинээр элсэн орсон нийт хүүхдийн 1556 нь буюу 48.6 хувь нь эмэгтэй хүүхэд байна.

Хүснэгт 3. Ерөнхий боловсролын сургуулийн зарим үзүүлэлт

Үзүүлэлт	2009/10	2010/11	2011/12	2012/13	2013/14	2014/15	2015/16
ЕБС-ийн тоо	20	20	21	24	22	22	29
Суралцагчдын тоо	16179	16101	16242	16581	16641	18878	22741
Үндсэн багшийн тоо	827	844	869	932	874	991	1191

Зураг 4. ЕБС-ийн тоо, төрийн бус сургуулийн тоо



Зураг 5.ЕБС-д суралцагчдын тоо, эмэгтэй



2009-2015 онуудад Хан-Уул дүүрэгт хүн ам шилжин ирэх хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотой дүүргийн ЕБС-д суралцагчдын тоо жил ирэх тусам өсч байна.

2015-2016 оны хичээлийн жилд ЕБС-д суралцагчдын тоо өмнөх оноос 3863 хүүхдээр буюу 20.5 хувиар өссөн байна.


Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчдын 12.6 мянган хүүхэд I-V анги, 5.8 мянга нь VI-IX анги, 4.4 мянган хүүхэд ахлах буюу X-XII ангид суралцжээ.

Зураг 6. ЕБС-ийн үндсэн багшийн тоо, сургуулийн өмчийн төрлөөр



2015-2016 оны хичээлийн жилд ЕБС-д ажиллаж байгаа үндсэн багш 1191 байгаагаас 935 нь төрийн өмчийн сургуульд, 256 нь төрийн бус өмчийн сургуульд ажиллаж байна. Үндсэн багшийн тоо өмнөх онтой харьцуулахад 200-аар буюу 20.2 хувиар өссөн байна. Хан-Уул дүүргийн ЕБС-ийн нэг үндсэн багшид 19 хүүхэд ногдож байна.

Зураг 7 . ЕБС-ийн үндсэн багшийн боловсролын түвшин



Багш нарын боловсролын мэргэжил дээшлүүлсэн байдлыг авч үзэхэд 2015-2016 оны хичээлийн жилд нийт үндсэн багш нарын 15.6 хувь нь магистр, 66.2 хувь нь бакалавр, 15.4 хувь нь дипломын боловсролтой багш нар тус тус эзэлж байна.

Мөн үндсэн багш нарын 491 нь буюу 41.2 хувь мэргэжлийн зэрэгтэй байгаа бөгөөд 0.7 хувь зөвлөх, 10.8 хувь тэргүүлэх, 29.6 хувь заах арга зүйч зэрэгтэй байна.

Зураг 8. ЕБС болон СӨББ-ын үндсэн багш нарын мэргэжлийн зэрэг



Зураг 9. Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш нарын мэргэжил дээшлүүлсэн байдал



Энэ хичээлийн жилд үндсэн багш нарын 23.8 хувь нь мэргэжил дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдсан бөгөөд, 2015-2016 оны хичээлийн жилд үндэсний сургагч багш 114, орон нутгийн сургагч багш 113, бүсийн хэмжээнд 57 багш нар мэргэжил дээшлүүлсэн байна.

Танилцуулга бичсэн: Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Э.Батзаяа